

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/11/НА-СТА-ТШЗ

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА
ДӨРВӨН ЗУУН АРВАН ТАВ ДУГААР НЭЭЛТТЭЙ, ХААЛТТАЙ
ХОРИХ АНГИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор: Б.Адъяасүрэн

Утас: 70273204 Цахим хаяг: adiyasuren@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.5.1 Завсрын аудитын талаар	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
5.1 Залруулсан алдаа	19
5.2 Албан шаардлага.....	19
5.3 Зөвлөмж	20
АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/69
танай _____-ны № _____-Т

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА ДӨРВӨН
ЗУУН АРВАН ТАВ ДУГААР НЭЭЛТТЭЙ,
ХААЛТТАЙ ХОРИХ АНГИЙН ДАРГА,
ХУРАНДАА Б.МЭНДСАЙХАН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа дөрвөн зуун арван тав дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа дөрвөн зуун арван тав дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа дөрвөн зуун арван тав дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн 60 жилийн ойг угтах ажлын хүрээнд алба хаагчдын ая тухтай байдлыг бүрдүүлэхээр урсгал засвар болон тохижилтын ажил хийгдсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Хууль зүй дотоод хэргийн сайдын 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А/95 тушаалын дагуу Төсвийн хяналтын нэгдсэн платформ нэвтрүүлэх арга хэмжээнд

дэмжлэг үзүүлэхээр Дата ланд технологи ХХК руу 4,000.0 мянган төгрөгийг шилжүүлж зардлаар бүртгэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	195,214,614.1	306,477,777.5
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	9,937,201.8	43,456,121.9
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	9,937,201.8	43,456,121.9
3121	Төгрөг	9,937,201.8	43,456,121.9
31211	Төрийн сангийн харилцах	9,937,201.8	43,456,121.9
35	БАРАА МАТЕРИАЛ	185,277,412.3	263,021,655.6
351	Түүхий эд материал	43,199,417.0	45,011,558.0
35110	Тусгай зориулалттай материал	42,953,319.0	45,011,558.0
35130	Эм боох материал	246,098.0	0.0
35300	Бэлэн бүтээгдэхүүн	8,500,926.3	13,511,403.4
354	Хангамжийн материал	75,187,069.0	108,018,694.2
35410	Бичиг хэргийн материал	1,584,200.0	1,617,200.0
35420	Аж ахуйн материал	59,649,196.0	80,367,396.0
35440	Түлш, шатах тослох материал	1,101,534.0	0.0
35450	Барилгын засварын материал	6,409,000.0	6,365,000.0
35460	Хүнсний материал	6,443,139.0	19,669,098.2
35600	Мал амьтад	58,390,000.0	96,480,000.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,110,728,051.2	2,998,164,732.5
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,110,728,051.2	2,998,164,732.5
392	Биет хөрөнгө	2,634,338,051.2	2,521,774,732.5
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,037,468,972.0	3,037,468,972.0
39202	Хуримтлагдсан элэгдэл	-595,205,313.5	-687,100,824.4
39203	Авто-тээврийн хэрэгсэл	215,737,826.0	230,737,826.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	-204,737,825.8	-210,702,111.5
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	459,607,083.9	460,393,583.9
39206	Хуримтлагдсан элэгдэл	-314,302,307.1	-347,168,364.7
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	28,647,251.0	32,869,299.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	-18,534,979.3	-20,380,991.8
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	25,657,344.0	25,657,344.0
393	Биет бус хөрөнгө	476,390,000.0	476,390,000.0
39301	Программ хангамж	4,437,692.3	4,437,692.3
39302	Хуримтлагдсан элэгдэл	-4,437,692.3	-4,437,692.3
39303	Бусад биет бус хөрөнгө	476,390,000.0	476,390,000.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,305,942,665.2	3,304,642,510.0
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	12,537,201.8	42,856,121.9
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	12,537,201.8	42,856,121.9
413	Өглөг	12,537,201.8	42,856,121.9
4136	Бусад өглөг	12,537,201.8	42,856,121.9
41361	Байгууллагад төлөх өглөг	2,600,000.0	0.0

41362	Хувь хүмүүст төлөх өглөг	9,937,201.8	42,856,121.9
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,293,405,463.4	3,261,786,388.1
51	Засгийн газрын хувь оролцоо	3,293,405,463.4	3,261,786,388.1
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	761,871,668.7	761,871,668.7
51101	Өмч: - төрийн	761,871,668.7	761,871,668.7
512	Хуримтлагдсан үр дүн	267,644,468.1	236,025,392.8
51210	Өмнөх үеийн үр дүн	353,491,555.4	267,644,468.1
51220	Тайлант үеийн үр дүн	-85,847,087.3	-31,619,075.3
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,263,889,326.6	2,263,889,326.6
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,305,942,665.2	3,304,642,510.0

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,105,867,023.2	5,952,202,315.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	324,050,823.2	2,217,554,015.2
120	Нийтлэг татварын бус орлого	324,050,823.2	2,217,554,015.2
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	206,216,043.6	1,246,271,278.6
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	42,760,060.0	201,058,542.0
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	45,621,204.0	73,930,000.0
120009	Бусад орлого	0.0	600,000.0
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	43,453,219.0	4,222,048.0
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	74,381,560.6	966,460,688.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,781,816,200.0	3,734,648,300.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,781,816,200.0	3,699,648,300.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,781,816,200.0	3,699,648,300.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.0	35,000,000.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.0	35,000,000.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,073,879,330.9	4,142,724,033.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,073,879,330.9	4,142,724,033.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,038,489,114.7	2,822,965,092.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,193,782,141.8	1,817,663,399.3
210101	Үндсэн цалин	760,664,619.1	1,119,446,553.3
210102	Нэмэгдэл	397,683,317.9	606,680,433.1

210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,764,142.4	23,546,800.0
210104	Урамшуулал	22,670,062.4	67,989,612.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,304,546.1	38,741,185.2
210201	Тэтгэврийн даатгал	0.0	91,514.4
210202	Тэтгэмжийн даатгал	0.0	10,766.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.0	8,613.1
210204	Ажилгүйдлийн даатгал	0.0	2,153.3
210205	Эрүүл мэндийн даатгал	24,304,546.1	38,628,138.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	204,478,967.5	272,134,945.8
210301	Гэрэл, цахилгаан	146,189,280.0	214,443,945.8
210302	Түлш, халаалт	49,930,687.5	50,691,000.0
210303	Цэвэр, бохир ус	8,359,000.0	7,000,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	43,356,158.0	71,847,804.0
210401	Бичиг хэрэг	2,920,516.0	3,653,000.0
210402	Тээвэр, шатахуун	31,114,966.0	46,558,834.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,963,676.0	998,970.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.0	92,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	732,000.0	1,000,000.0
210408	Бараа материал акталсны зардал	6,625,000.0	19,545,000.0
2105	Нормативт зардал	340,669,498.6	415,764,391.3
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	10,079,854.0	8,084,934.0
210502	Хоол, хүнс	292,975,073.4	372,352,058.8
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	37,614,571.3	35,327,398.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	55,343,886.0	30,457,500.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,263,882.0	3,213,500.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	129,200.0	0.0
210604	Урсгал засвар	53,950,804.0	27,244,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,854,374.0	12,501,200.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,683,674.0	5,866,600.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	847,100.0	847,100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	521,200.0	298,300.0

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	147,900.0	0.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	488,700.0	4,489,200.0
210807	Газрын төлбөр	1,165,800.0	1,000,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	159,699,542.8	163,854,666.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,188,106.6	30,592,500.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	690,600.0	690,300.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	149,820,836.2	132,571,866.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,390,216.2	1,319,758,941.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,001,280.0	1,202,324,049.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.0	1,200,399,049.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,001,280.0	1,925,000.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,388,936.2	4,118,850.7
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,388,936.2	4,118,850.7
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	20,000,000.0	113,316,042.0
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,000,000.0	113,316,042.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	31,987,692.3	1,809,478,281.3
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	31,987,692.3	1,809,478,281.3

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,946,115,030.9	4,251,643,511.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	169,687,767.1	495,365,907.9
120	Нийтлэг татварын бус орлого	169,687,767.1	495,365,907.9
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	169,687,767.1	494,765,907.9
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	169,687,767.1	494,765,907.9
120009	Бусад орлого	0.0	600,000.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,776,427,263.8	3,756,277,603.5
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,776,427,263.8	3,731,277,603.5
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,776,427,263.8	3,731,277,603.5
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.0	25,000,000.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.0	25,000,000.0

2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,960,320,536.0	4,218,124,591.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,960,320,536.0	4,218,124,591.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,930,319,256.0	2,901,736,346.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,193,782,141.8	1,817,663,399.3
210101	Үндсэн цалин	760,664,619.1	1,119,446,553.3
210102	Нэмэгдэл	397,683,317.9	606,680,433.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,764,142.4	23,546,800.0
210104	Урамшуулал	22,670,062.4	67,989,612.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,304,546.1	38,741,185.2
210201	Тэтгэврийн даатгал	0.0	91,514.4
210202	Тэтгэмжийн даатгал	0.0	10,766.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.0	8,613.1
210204	Ажилгүйдлийн даатгал	0.0	2,153.3
210205	Эрүүл мэндийн даатгал	24,304,546.1	38,628,138.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	201,754,880.0	272,134,945.8
210301	Гэрэл, цахилгаан	146,189,280.0	214,443,945.8
210302	Түлш, халаалт	47,206,600.0	50,691,000.0
210303	Цэвэр, бохир ус	8,359,000.0	7,000,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	40,733,492.0	50,648,270.0
210401	Бичиг хэрэг	2,920,816.0	3,100,000.0
210402	Тээвэр, шатахуун	35,117,000.0	45,457,300.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,963,676.0	998,970.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.0	92,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	732,000.0	1,000,000.0
2105	Нормативт зардал	264,145,510.0	359,746,900.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	9,509,900.0	7,000,000.0
210502	Хоол, хүнс	254,635,610.0	352,746,900.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	53,531,000.0	31,729,200.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,453,000.0	4,000,000.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	129,200.0	529,200.0
210604	Урсгал засвар	33,948,800.0	27,200,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	150,653,586.1	298,289,645.9

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	147,482,886.1	291,655,045.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	847,100.0	847,100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	521,200.0	298,300.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	147,900.0	0.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	488,700.0	4,489,200.0
210807	Газрын төлбөр	1,165,800.0	1,000,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,414,100.0	32,782,800.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	723,800.0	32,092,500.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	690,300.0	690,300.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,001,280.0	1,316,388,245.2
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	20,000,000.0	113,316,042.0
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	20,000,000.0	113,316,042.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,001,280.0	1,202,324,049.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.0	456,720,800.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.0	743,678,249.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,001,280.0	1,925,000.0
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.0	748,154.2
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.0	748,154.2
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-14,205,505.0	33,518,920.1
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-14,205,505.0	33,518,920.1
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	24,142,706.9	9,937,201.8
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,937,201.8	43,456,121.9

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	761,871,668.7	2,263,889,326.6	353,491,555.4	3,379,252,550.7
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	761,871,668.7	2,263,889,326.6	353,491,555.4	3,379,252,550.7
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	0.00

C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(85,847,087.3)	(85,847,087.3)
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	761,871,668.7	2,263,889,326.6	267,644,468.1	3,293,405,463.4
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	761,871,668.7	2,263,889,326.6	181,797,380.8	3,207,558,376.1
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	761,871,668.7	2,263,889,326.6	267,644,468.1	3,293,405,463.4
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(31,619,075.3)	(31,619,075.3)
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	761,871,668.7	2,263,889,326.6	236,025,392.8	3,261,786,388.1

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,762,390,800.00	4,217,376,437.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,762,390,800.00	4,217,376,437.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,558,521,500.00	2,901,736,346.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,817,663,400.00	1,817,663,399.29
210101	Үндсэн цалин	1,126,227,700.00	1,119,446,553.31
210102	Нэмэгдэл	577,276,900.00	606,680,433.11
210103	Унаа хоолны хөнгөлөлт	36,084,200.00	23,546,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,483,900.00	38,741,185.20
210201	Тэтгэврийн даатгал	0.00	91,514.40
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	10,766.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	8,613.12
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	2,153.28
210205	Эрүүл мэндийн даатгал	40,483,900.00	38,628,138.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	272,883,100.00	272,134,945.82
210301	Гэрэл, цахилгаан	215,192,100.00	214,443,945.82
210302	Түлш, халаалт	50,691,000.00	50,691,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	50,649,300.00	50,648,270.00
210401	Бичиг хэрэг	3,100,000.00	3,100,000.00
210402	Тээвэр, шатахуун	45,457,300.00	45,457,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	92,000.00	92,000.00

2105	Нормативт зардал	334,746,900.00	359,746,900.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,000,000.00	7,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,729,200.00	31,729,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	529,200.00	529,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,582,900.00	298,289,645.86
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,866,600.00	291,655,045.86
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300,000.00	298,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	80,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,489,200.00	4,489,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,782,800.00	32,782,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,092,500.00	32,092,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,203,869,300.00	1,315,640,091.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	113,316,042.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	456,720,800.00	456,720,800.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	744,468,500.00	743,678,249.00
0	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,762,390,800.0	4,232,784,904.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,699,648,300.0	3,738,018,997.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	60,000,000.00	60,000,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	60,000,000.00	60,000,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	60,000,000.00	60,000,000.00
2105	Нормативт зардал	25,000,000.00	25,000,000.00
210502	Хоол, хүнс	25,000,000.00	25,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,000,000.00	10,000,000.00
210604	Урсгал засвар	10,000,000.00	10,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,000,000.00	25,000,000.00

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,000,000.00	25,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	25,000,000.00	25,000,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	25,000,000.00	25,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	25,000,000.00	25,000,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа дөрвөн зуун арван тав дугаар нээлттэй, хаалттай хорих анги нь хорих ял эдлүүлэх чиг үүрэг бүхий Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт тайлангаа нэгтгэдэг Хууль зүйн яамны харьяа төрийн байгууллага юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хэмжээнд 2023 оныг “Байгууллагын үйл ажиллагааг цахим болгох, аюулгүй байдал, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, албан хаагчийн хөгжлийг дэмжих” жил болгон зарлаж, Байгууллагын үйл ажиллагаанд технологийн дэвшлийг нэвтрүүлэн, цахим болгох ажлыг эрчимжүүлэх, Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга бат, дэг журмыг чанд сахих, албан үүргээ нэр төртэй, шударгаар гүйцэтгэн, иргэдийн байгууллагад итгэх итгэлийг нэмэгдүүлэх, Ногоон хөгжлийг дэмжиж “100 сая мод” хөдөлгөөн өрнүүлэх зорилтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Тус анги нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 9 ажил үйлчилгээг төлөвлөсөн хугацаанд биелэлтийг ханган ажилласнаар гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 100 хувьтай байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус анги нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Эрүүгийн хууль, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль зэргийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын хөдөлмөрийн дотоод журам болон холбогдох баримт бичигт өөрчлөлт оруулан мөрдөж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа дөрвөн зуун арван тав дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн даргын 2023 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/04 дүгээр “Дотоод хяналт шалгалт явуулах тухай” тушаалаар алба нэгжүүдэд дотоод хяналт шалгалт явуулах хуваарь болон дотоод хяналт шалгалт явуулах албан тушаалтнуудыг баталж, биелэлтийг тухай бүр дүгнэж танилцуулахыг үүрэг болгосон дагуу дотоод хяналт шалгалтыг явуулж, үр дүнг танилцуулж, заавар зөвлөмж өгч ажилласан байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа дөрвөн зуун арван тав дугаар нээлттэй, хаалттай хорих анги нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа дөрвөн зуун арван тав дугаар нээлттэй, хаалттай хорих анги нь ШШГЕГ-ын даргын 2020 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн А/134 дүгээр тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа дөрвөн зуун арван тав дугаар нээлттэй, хаалттай хорих анги нь 2023 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,300.2 мянган төгрөгөөр буюу 0,04 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	9,937.2	43,456.1	33,518.9
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	185,277.4	263,021.7	77,744.2
Үндсэн хөрөнгө	3,110,728.1	2,998,164.7	(112,563.3)
Нийт хөрөнгө	3,305,942.7	3,304,642.5	(1,300.2)
Өр төлбөр	12,537.2	42,856.1	30,318.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,293,405.5	3,261,786.4	(31,619.1)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,305,942.7	3,304,642.5	(1,300.2)

Дээрх хүснэгтээс харахад: Бараа материал дансны хувьд тусгай зориулалтын материал 2,058.0 мянган төгрөг, бэлэн бүтээгдэхүүн 5,010,477.0 мянган төгрөг, бичиг хэргийн материал 33,000.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, эм боох материал 246,098.0 мянган төгрөг, түлш, шатах тослох материал 1,101,534.0 мянган төгрөг, барилгын засварын материал 44,000.0 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс 2023 онд тээврийн хэрэгсэл 15,000.0 мянган төгрөг, машин тоног төхөөрөмж 787.0 мянган төгрөг, тавилга эд хогшил 4,222.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд хөрөнгө хасагдаагүй байна.

Тайлант онд улсын төсвийн хөрөнгөөр 787.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж худалдан авч, үнэ төлбөргүй хүлээн авсан 15,000.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 4,222.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил хүлээн авч, үндсэн хөрөнгө данс нэмэгдсэн байна. Өр төлбөр данс 30,318.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь хоригдлуудын нэрийн данс өссөнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,261,786.0 мянган төгрөг болж 31,619.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

2023 оны төсвийн төсөөллийг 2,486,819.83 мянган төгрөгөөр төсөвлөж саналыг хүргүүлсэн бөгөөд байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж бараа материалын зардал, нормативт зардал, эд хогшил, урсгал засварын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, бараа үйлчилгээний зардлуудыг жишиг нормативын дагуу 400 хоригдлоор тооцоолсон. 2023 оны төсөв 1,661,195.90 мянган төгрөгөөр батлагдсан. Энэ нь 825,623.93 мянган төгрөгөөр буурч батлагдсан байна.

2023 онд батлагдсан төсөвт өөрчлөлт орж 3,699,648.3 мянган төгрөгийн санхүүжилт авсан. Энэ нь 2023 онд алба хаагчдын цалин шат дараатайгаар нэмэгдсэн, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг олгосон зэргээс шалтгаалан улсын төсвийн санхүүжилтийн хэмжээ нэмэгдсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 3,699,648.3 мянган төгрөгөөр буюу 2,038,452.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,699,648.3 мянган төгрөгийг улсын төсвөөс 35,000.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,699,648.3 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 62,742.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,758,271.95 мянган төгрөг буюу 99,9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 3,370.2 мянган төгрөгөөр дутуу зарцуулж, туслах үйл ажиллагааны орлогыг 748.2 мянган төгрөгөөр төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	/мянган төгрөгөөр/			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70705 шүүхийн шийдвэр гүйцэтгэл 80101 үндсэн үйл ажиллагаа	2,495,779.0	2,493,953.6	1,825.4	99.9%
2	70705 шүүхийн шийдвэр гүйцэтгэл 80802 нэг удаагийн тэтгэмж	1,203,869.30	1,202,324.05	1,545.2.	99.9%
3	70711 шүүгч болон гэрч хохирогчийн /80101 үндсэн үйл ажиллагаа	500.0	0	0	0%
4	70705 шүүхийн шийдвэр гүйцэтгэл 80102 туслах үйл ажиллагаа	62,742.50	61,994.3	748.1	98.8%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсөв захирагчаас 35,000.0 мянган төгрөг, өөрийн орлогоос 25,000.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа дөрвөн зуун арван тав дугаар нээлттэй, хаалттай хорих анги тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар хоол хүнсэнд 25,000.0 мянган төгрөг, урсгал засварын зардалд 10,000.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 25,000.0 мянган төгрөг, нийт 60,000.0 мянган төгрөгийг зарцуулсан байна

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 2 хөтөлбөрийн 4 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70705 шүүхийн шийдвэр гүйцэтгэл	2023.01.01-2023.12.31	Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах	99.9%	3,762,390.80	3,758,271.95
2	70711 Шүүгч болон гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах.	2023.01.01-2023.12.31	хэвийн үйл ажиллагааг хангах	0%	500.0	0.0

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа дөрвөн зуун арван тав дугаар нээлттэй, хаалттай хорих анги нь тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр 64,936.2 мянган төгрөгийн шатахуун, түлш халаалтын үйлчилгээг тендер шалгаруулалтын онцгой журмаар, 180,000.0 мянган төгрөгийн хоол хүнсний барааг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, 4,000.0 мянган төгрөгийн барааг шууд худалдан авалтаар авахаар, нийт 248,936.2 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээг худалдан авахаар төлөвлөсөн байна.

Түлш халаалт нийлүүлэх гүйцэтгэгчээр Хэрлэнгийн боргио ХХК, Хоол хүнсний бараа нийлүүлэх гүйцэтгэгчээр Д.Наранцэцэг, Андууд-Ар ХХК шалгарч гэрээ байгуулах эрх олгон бараа үйлчилгээг худалдан авч ажилласан.

Шатахуун худалдан авах нээлттэй тендерийг 2 удаа зарласан бөгөөд санал ирүүлсэн оролцогч байгаагүй тул Тэс петролиум, Гурван цагаан далай ХХК-аас шууд худалдан авалт хийсэн.

Гүйцэтгэлээр 403,3952.0 мянган төгрөгийн худалдан авалтыг төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааны зохих журмаар хийсэн байна. Худалдан авалтын дүн өссөн нь төсөв тодотгон нэмэгдсэнтэй холбоотой байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Адъяасүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа дөрвөн зуун арван тав дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн 2023 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 01/64 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа дөрвөн зуун арван тав дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн 2023 оны баталсан төсвийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа дөрвөн зуун арван тав дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн батлагдсан 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт орлого 1,988,032.2 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 29,820.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 22,365.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа дөрвөн зуун арван тав дугаар нээлттэй, хаалттай хорих анги тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон зардлууд гараагүй, өглөг үүсгээгүй, төсвийн хөрөнгийг хэмнэлттэй зарцуулан ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа дөрвөн зуун арван тав дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт мэдээлбэл зохих 159 мэдээллээс 3 мэдээллийг хугацаа хоцроож, 156 мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлсэн байна. Үүнд: цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 25 орлогын, 89 зарлагын мөнгөн гүйлгээг болон өмч хөрөнгө, мөнгө зарцуулах 13 шийдвэрийг хуулийн хугацаанд байршуулж мэдээлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа дөрвөн зуун арван тав дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн, биелэлтийг 2023 оны 7 дугаар сарын 03-ны өдөр ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	2	978,814.4	2	978,814.4	100%
Нийт дүн	2	978,814.4	2	978,814.4	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа дөрвөн зуун арван тав дугаар нээлттэй, хаалттай хорих ангид дараагийн аудитаар Төсвийн хяналтын нэгдсэн платформ болох Дата ланд технологи ХХК-ийн нэвтрүүлж буй программын ашиглалтыг үзэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 35,690.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 35,690.0 мянган төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

1. Байгууллагаас гаргасан төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах тухай 35,550.0 мянган төгрөгийн 8 шийдвэрийг шилэн дансанд оруулж мэдээлээгүй. Энэ шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

2. Хулдаасан хэвлэл 100.0 мянган төгрөг, машины дугаар 40.0 мянган төгрөг нийт 140.0 мянган төгрөгийн бараа материалын шинжтэй хөрөнгийг орлогод авахгүйгээр шууд зардлаар хаасан. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

3. Үр дүнгийн тайланд орлого болон үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал, үндсэн хөрөнгийг Э-тайлантай зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт байхгүй.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага байхгүй.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

5.3 Зөвлөмж

1. Тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Мөнгөн гүйлгээний журналаар 8 албан хаагчийн тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж, 36 албан хаагчийн хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийн гүйлгээг тооцооны дансаар дамжуулалгүйгээр зардлаар хаасан. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна..

Өгсөн зөвлөмж: Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж болон хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийн гүйлгээг гүйлгээг тооцооны дансаар дамжуулж хэвших зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлагналтай холбоотой алдаа	2	140.0			2	140.0	2	140.0				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой	1	35,550.0	1	35,550.0			1	35,550.0				
Дүн	3	35,690.0	1	35,550.0	2	140.0	3	35,690.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		/мянган төгрөгөөр/				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Нэг удаагийн тэтгэмжийн гүйлгээг тооцооны дансаар дамжуулалгүйгээр зардлаар хаасан.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Дүн	1	-	-	-			1	-	-	-	-	-

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn